



Тояма хот дахь өндөр настныг асрах төв ЭБИС



Өндөр настанд олгох үйлчилгээний төрлүүд

- Асаргааны төвд урт хугацаагаар группээр амьдрахад зориулагдсан үйлчилгээ
- Гэртээ амьдардаг боловч асаргаа шаардлагатай өндөр настанд зориулагдсан үйлчилгээ
- Асаргааны төвд өдрөөр ирж үйлчлүүлэх үйлчилгээ

АСАРГААНЫ ТӨВД УРТ ХУГАЦААГААР ГРУППЭЭР АМЬДРАХАД ЗОРИУЛАГДСАН ҮЙЛЧИЛГЭЭ ГЭЖ ЮУ ВЭ?

Амьдралын өдөр тутмын хэвийн нөхцөлийг бүрдүүлсэн орчинд асаргаа шаардагдах өндөр настныг урт хугацаатайгаар, группээр байршуулан, өдөр тутмын асаргаа, тусламж дэмжлэг үзүүлэх үйлчилгээ бөгөөд тэнэгрэл (dementia) явагдаж буй өндөр настанд чиглэнэ.

Дээд тал нь есөн өндөр настан групп болж хамтдаа байрлах ба ээлжийн асрагч тэдгээр ахмадуудын өдөр тутмын эрүүл мэндийн байдлыг хянаж, амар тайван ая тухтай цагийг өнгөрүүлэхэд нь тусална.

Үйлчилгээний агуулга

- Хоол хийхэд нь туслах: Хоол хийх, аягалах, идэхэд нь туслах
- Ариун цэвэр сахихад нь туслах: Бие засах, усанд орох, өрөөгөө цэвэрлэх, хувцас хэрэглэлээ угааж эвхэхэд нь туслах
- Салхинд хамт гарах: Цэцэрлэгт хүрээлэнд салхилах, дэлгүүр орох, гадуур хооллох, кафе орох, бага сургуулийн суралцагчдын өдөрлөг болон бүс нутагийн арга хэмжээнд оролцоход нь хамт явж, асран хамгаалах
- Чөлөөт цагийг өнгөрүүлэхэд нь туслах: Амттан хийх, яриа хөөрөх, дуулах, дасгал хийх, сонирхолын дагуух зүйлээ (оригами хийх, бийрээр ханз бичих, нэхмэл нэхэх, зураг зурах гэх мэт) хийхэд нь туслах.
- Баяр тэмдэглэх: Төрсөн өдөр, ханами, зуны баярт өдөрлөг, ахмадын өдөр, зул сарын баяр зэрэг тэмдэглэлт өдрүүдийг хамтдаа тэмдэглэх



ГЭРТЭЭ АМЬДАРДАГ БОЛОВЧ АСАРГАА ШААРДЛАГАТАЙ ӨНДӨР НАСТАНД ЗОРИУЛАГДСАН ҮЙЛЧИЛГЭЭ ГЭЖ ЮУ ВЭ?

Өөрийн гэртээ эсвэл хүүхдүүддээ ойр болон нутагтаа амьдрах хүсэлтэй өндөр настанд зориулсан үйлчилгээ бөгөөд үйлчлүүлэгчийн хүсэлтэд нийцүүлэн:

- Ээлжийн асрагч гэрт нь очиж эргэх, асрах, туслах
- Өдрийн цагаар асаргааны төв дээр байрлуулах
- Асаргааны төвд цөөн хоногоор хоноглуулах

байдлаар үйлчлүүлэгчийг 365 хоног, 24 цагаар харж хандаж, асран хамгаална.

Тэнэгрэл (dementia) явагдаж буй өндөр настны бодит хэрэгцээнд туслах, хань болох, өдрийг хамтдаа өнгөрүүлэх зэргээр тэднийг амар амгалан, ая тухтай амьдруулахын тулд асаргааны менежер, асрагч, сувилагч нар хамтран асарч сувилана.

Үйлчилгээний агуулга

Нийт үйлчлүүлэгч нарт:

- Амьдралын мөн чанарыг дээшлүүлэхэд чиглэсэн урт хугацааны үйл ажиллагааг үйлчлүүлэгч тус бүрээр төлөвлөж, хөтөлбөр гаргах
- Үйлчлүүлэгчийн санал хүсэлтийг хүлээн авах, шийдэх, зөвлөх



Ээлжийн асрагч гэрт нь очиж асрах тохиолдолд:

- Биеийн асаргаа болох хооллох, усанд орох, толгой гар хөлөө угаах, биеэ чийгтэй алчуураар арчих, бие засах, хувцсаа өмсөх тайлах зэрэгт нь туслах. Хэвтэрт орсон үйлчлүүлэгчийн сүүжний яс цоорохоос сэргийлж биеийн байрлалыг өөрчлөх, цагаан хэрэглэл, дэвсгэрийг солих, алхах болон тэргэнцэр дээр сууж босоход нь туслах
- Цагийг үр ашигтай өнгөрүүлэхэд нь тусалж дэлгүүр хамт орох, хоол хийх, угаалга цэвэрлэгээ хийх, хувцасаа эвхэх цэгцлэх, эм авах зэрэгт хамт байж туслах
- Машин унаанд сууж буух, гадуур гарах болон сонирхолтой зүйлээ хийхэд нь туслах

Асаргааны төвд цөөн хоногоор хоноглох тохиолдолд:

- Өдөр тутмын үйлчилгээ: Хоол тэжээлийн мэргэжилтний зааврын дагуу эрүүл тэжээллэг амттай хоолоор үйлчлэх, үйлчлүүлэгчийн эрүүл мэндийн байдалд тохируулж усанд оруулах эсвэл чийгтэй алчуураар биеийг нь арчих, живхийг солих, бие засуулах
- Эрүүл мэндийн үйлчилгээ: Сувилагч болон эрүүл мэндийн байгууллагатай хамтран, үйлчлүүлэгчийн эрүүл мэндийн байдлыг хянаж, шаардлагатай нөхцөлд эмнэлэгт хэвтүүлэх
- Чөлөөт цагийг үр дүнтэй өнгөрөөхөд нь туслах: Тухайн үйлчлүүлэгчийн биеийн байдлыг харгалзан дасгал гимнастик хийлгэх, тоглоом тоглуулах, сонирхолтой зүйлийг нь хийлгэх, тэмдэглэлт баярт оролцуулах байдлаар идэвхтэй байхад нь тусалж асран хамгаалах
- Бусад: Өндөр настны зориулалтын машин унаагаар гэрээс нь тосч авах, гэрт нь хүргэх



АСАРГААНЫ ТӨВД ӨДРӨӨР ИРЖ ҮЙЛЧЛҮҮЛЭХ ҮЙЛЧИЛГЭЭ ГЭЖ ЮУ ВЭ?

Өндөр настанг зөвхөн өдрийн цагаар асаргааны төв дээр байрлуулж амьдралын өдөр тутмын үйлчилгээг үзүүлж, дэмжин туслах үйлчилгээ юм.


Үйлчилгээний агуулга

- Асаргааны төв дээр байх өдрийн цагт тэднийг усанд оруулах, өдрийн хоол хамт идэх, ахуй амьдралынх нь тухай асууж ярилцах, бие сэтгэлийн байдлыг ажиглах, биеийн хөдөлгөөний дасгал хийлгэх, иллэг массаж хийх, цагийг үр дүнтэй хөгжилтэй өнгөрөөхөд нь туслах
- Өндөр настны зориулалтын машин унаагаар үйлчлэх
- Асаргааны төвийн нийгмийн ажилтан, асрагч, сувилагч, дасгалжуулагч, бариа засалч нар хамтран үйлчлүүлэгчийн бие сэтгэл зүйд нийцүүлэн амьдралын таатай орчинг бүрдүүлж, өндөр настны эрүүл мэндийг хамгаалах, идэвхтэй насжилтыг дэмжихэд чиглэсэн бүхий л үйлчилгээг үзүүлэх



Бидэнтэй холбогдох

Манай төв нь монгол ажилчин болон монгол төлөөлөгчийн газартай тул асрахуйн чиглэлээр сурч ажиллах сонирхолтой хүмүүс доорх хаягаар холбогдоно уу.



**Шуудангийн дугаар 931-8403,
Тояма муж, Тояма хот, Табата 852-3,
Япон улс.**

TEL: 076-471-7841

FAX: 076-471-7851

Имэйл: ebisutoyama@gmail.com

